

ШҮҮМЖ, НОМ ЗҮЙ

**«ХЯТАДЫН ЭРТНИЙ УМАРД ХЯЗГААРЫН АЙМАГ
УГСААТНЫ ТОВЧ ТҮҮХ», Хөх хот, 1979 он**

(Шүүмж)

1979 онд Өвөр Монголын ардын хэвлэлийн хорооноос нийтлүүлсэн энэ номыг Өвөр Монголын өөртөө засах орны монгол хэл бичиг, уран зохиол, түүх судлах хүрээлэнгийн түүхийн тасаг, Өвөр Монголын их сургуулийн монголын түүх судлах тасгаас эрхлэн хэвлүүлжээ.

Уул зохиол 4 бүлэг, 16 зүйл, 33 гарчигтай бөгөөд 1-р бүлгийг «Байлдаант улс, Цинь, Хан улсын үе дэх умард нутгийн үндэстнүүд» гэж нэрлээд түүнд Хүннү, Дунху, Ухань, Сяньби, Линхү, Динлин аймгуудыг оруулжээ. II бүлгийг «Вэй Цзин өмнө, хойд төрийн үе дэх умард нутгийн үндэстнүүд» гээд түүнд Тоба, Жужан, Телэ аймгуудыг хамааруулжээ. III бүлэг «Сун, Тан улсын үе дэх умард нутгийн үндэстнүүд» нэртэй. Түүнд Түрэг, Уйгур, Киргиз аймгуудыг хамаатуулан бичжээ. IV бүлгийг «Таван төр, арван улс ба Сун Ляо, Алтан (Цзинь) улсын үе дэх умард нутгийн үндэстнүүд» гээд тэнд Кидан, Зүрчид, баруун Тангудыг хамруулан бичжээ.

Ийнхүү уг номын зөвхөн бүлэг, зүйл, гарчигууд л хятадын цагаан хэрмээс урагш, хойш сэлгэн нутаглаж байсан монголын эртний биеэ даасан улс аймгуудыг хятадын тухайн үеийн төр улсын харъяанд байсан умард нутгийн үндэстнүүд мэтээр дүрслэж, түүхэн үнэнийг зориудаар гуйвуулан бичсэн нь харагдаж байна.

Уг номд Хүннү улсын тухай бичихдээ «Хятад улсын доторхи их говийн хойд, өмнөд тал нутаг нь эртнээс манай улсын түүхэн дэх умард нутгийн нүүдэлчин олон үндэстний үйл ажиллагааны талбар болж байв»¹ гээд цааш нь Монголын «Ноён уулын булшнаас олдсон хүрэл, төмөр сав суулганд хятад дархчуудыг дууриасан хийц их байгаа нь хан үндэстний дархны гараар тэр үеийн зүйл бүтээгдэж байсны нотолгоо»² хэмээн тэмдэглэжээ. Гэтэл түүхийн үнэн баримт, сурвалж бичгүүд үүнийг үгүйсгэдэг билээ. Хүннү нар бол Төв Азийн эртний нэрд гарсан томоохон улс аймгуудын нэг юм. Тэд МЭӨ 209 онд одоогийн БНМАУ-ын нутгаар төвлөсөн нүүдлийн хүчирхэг гүрэн байгуулж 300-гаад жил оршин байгаад мөхжээ. Хүннү улс Хятадын бүрэлдэхүүн хэсэг биш, тусгаар оршин байсныг баталж «МЭӨ III зууны сүүлчээр Модун шаньюйн үед хүннү улс хүчирхэгжиж умар өмнийн нүүдэлчин олон аймгийг номхотгоод, Хүннү улс Дундад улстай эн чацуу болов»³ гэж хятад сурвалжид бичсэн байдаг билээ.

Хүннүгийн үеийн булшнаас олдсон ширэм хайлж байсан эд баримтыг тэд тайлбарлахдаа дан ганц хятад дархчуудын бүтээсэн зүйлс, хятадын нутаг дэвсгэрт багтаж байсан хүннүчүүдийн эд, өлгийн зүйлс гэж тайлбарлах нь түүхэн үнэнийг гуйвуулсан учир дутагдалтай дүг-

¹Эртний хятадын умард хязгаарын аймаг, угсаатны товч түүх. Хөх хот. 1977 он. 4-р тал.

²Мөн тэнд. 11-р тал.

³БНМАУ-ын түүх. 1 боть. УБ., 1966, 83-р тал.

нэлт юм. БНМАУ-ын нутаг дэвсгэрээс олдсон Хүннүгийн гар үйлдвэрийн байдлыг тодорхойлох археологийн арвин олдворууд бодит үнэнийг гэрчлэх тодорхой баримт болдог. Хүннү нарын дунд балгас, суурингууд удаа дараа байгуулагдаж заримд нь гар үйлдвэр дэлгэрч, төмрийн хүдэр хайлж, төмөрлөг боловсруулж байсан байна. «Хүннү зэргэлдээ аймгуудтайгаа арилжаа, наймаа хийхийн хажуугаар Хятад, Дундад Ази зэрэг улс орнуудтай худалдааны харилцаа бүхий болж мал аж ахуйгаас гарах түүхий эд, ангийн үслэг, мөн гар үйлдвэрийн зарим бүтээгдэхүүнийг арилжих явдал хүннүгийн аж ахуй, эдийн засгийн чухал суурийг эзэлж байсан байна»⁴

Түүнчлэн Хүннүгийн тухай дурсгалуудыг малтаж шинжлэхэд Хятадын хан улсын үеийн эдийн боловсролын дурсгалууд олдож байдгаас гадна грек, бактри гаралтай эдлэлүүд ч олддог нь хүннүчүүд тэр үеийнхээ хөгжилтэй орнуудтай эдийн засаг, соёлын харилцаатай байсныг гэрчилж байдаг билээ.

Дээр өгүүлсэн номын дотор Дунху, Ухуань, Сяньби аймгуудын түүхийг бичихдээ, тэднийг мөн л «манай улсын (хятадын) зүүн хойт зүгийн эртний цөөнхи үндэстэн»⁵ гэж үзжээ. Энэ бол түүхэн үнэнд огт нийцэхгүй зүйл юм. МЭӨ III зууны эцсээр Хүннү гүрэн тогтох явц дундуур, Дорнод ху угсааны нэр нь тодроогүй гурван аймаг монголын түүхэнд гарч ирсэн байна. Дээрхи гурван аймгийн хоёр нь монголын зүүн өмнөд нутгийн Шар мөрөн, Лууха голын савд орших Сяньби, Ухуань хоёр уулсын орчимд нутагшсаар тэр газрын нэрийг авч гурав дахь нь Онон мөрний адаг, Өргөнө голоор Тоба нэртэй оршин суусныг түүхэнд тэмдэглэсэн байдаг. Сяньби аймгууд МЭ 80—90-ээд онд Хүннү гүрний нутгийг эзэлж, бас Ухуань нартай зах нийлэх хэсгийг харъяалж, уудам нутагтай болоод зарим хүн ам нь баруун хойш Хүннү гүрний хуучин нутагт аажмаар шилжин суурьшиж байв. Тэд III зууны тэргүүн хагаст улсын дотоодын язгууртан ноёдын эрх мэдэл булаалдсан тэмцэлд өртөгдөж түүнийг нь хятадын дарлагч анги улам дэвэргэн хурцатгаснаар III зууны дунд үе болж ирэхэд Сяньби улс задран хэд хэдэн тусгаар аймаг болон салснаас Муюн, Тоба аймгууд гарч ирсэн түүхтэй билээ.

Түүнчлэн уг номд Жужаны хаант улсын үеийн түүхийг бичихдээ хятад улсын харъяаны нэгэн цөөнх үндэстний сэргэн мандалтын үе мэтээр бичихийг оролджээ. Мөн Түрэг улсын талаар дурьдсан нь: «Түрэгийн хаант улсаас эхлэн манай улсын умард нутаг дахь нүүдэлчин үндэстнүүд удаан хугацааны турш ноёрхож байсан боолын системийн хазаарлалтаас ангижирч, аажмаар феодалын нийгэмд шилжин орсон юм»⁶ гэжээ.

Гэтэл, үнэн хэрэгтээ Монгол нутагт Жужаны дараа бусад нүүдэлчдийн дундаас товойн гарч тэднийг зонхилох болсон аймаг нь Түрэгүүд байсан юм. VI—VIII зууны үед Түрэг хэлтэй овог аймгуудын улс төрийн нэгдэл болон феодалын түрүү улс Орхон голын сав газраар оршин тогтнож байсан билээ. Түрэгийн хаант улсыг мөхсөний дараа түүний байр суурийг Уйгурын хаант улс эзэлж VIII—IX зууны үед монгол нутагт ноёрхож байжээ. Хятадын түүхийн зарим зохиолд Уйгур нарыг Хүннүгээс гаралтай гэдэг боловч энэ нь баримтаар бүрэн нотлогдоогүй юм. Гэтэл, уг зохиолд Телэ аймгаас гаралтай гэж нотлохыг оролджээ. Түүхэн баримтанд тулгуурлавал Түрэгийн хаант улс мөх-

⁴БНМАУ-ын түүх. 1 боть. 90-р тал.

⁵Эртний хятадын умард хязгаарын аймаг, угсаатны товч түүх. Хөх хот, 1979, 31 -р тал.

⁶Эртний хятадын умард хязгаарын аймаг, угсаатны товч түүх. Хөх хот. 1979. 119-р тал.

сөний дараагаар Уйгурууд түүхийн тавцанд товойн гарч төр улсаа VIII зууны үед байгуулсан Төв Азийн Түрэг удмын аймаг байжээ. Нутаглаж байсан газрыг нь V—IX зууны эхний үеэр авч үзэхэд Их говийн өмнүүр, хойгуур, Сэлэнгэ, Хар Ирчис голын сав газраар, Изинэ (Эзэн) голоос баруун хойш Тэнгэр уулсаар байрлаж байсан байна.

Эл номд Кидан гүрнийг мөн л өөрийн улсын (хятадын) хойд зүгийн нүүдэлчин аймаг гэж үзэх оролдлого хийгээд улмаар цааш нь «Ляо улсын хилийн дотор оршиж байсан олон үндэстний дотроос Кидан нь ноёрхогч үндэстэн байсан ба ноёрхогдогч үндэстэн нь хан, бохай, чи, зүрчид, уйгур, монгол гэх мэт байв»⁷ гэж түүхийг гуйвуулжээ. Ийнхүү уг номыг уншиж үзэхэд хятадын маоист түүхчид дэлхийн улс орнуудын түүхийг гуйвуулан үздэгийнхээ нэгэн адил монголын нүүдэлчин улс аймгуудыг хятадын төр улсын харьяаны болгон харуулахыг оролдоод улмаар эдгээр аймгуудын түүх, соёл, нутаг дэвсгэрийг хятадын салшгүй хэсэг болгохын тулд түүхэн үнэнийг гуйвуулан завхруулсан нь илт харагдаж байна.

Түүхийг бодитой, эрүүл саруул ухаанаар тунгаан үзвэл дээр дурдсан улс аймгууд нь хэзээ ч хятадын харьяаны байгаагүй ба харин ч өөрийн монгол газар нутагтаа өөрийн төр улсаа байгуулан, Цагаан хэрмээс дотогш орших хятад улстай худалдааны харилцаа бүхий эн чацуу эрхтэй байсныг өнөөгийн үе хүртэл уламжилж ирсэн түүхэн баримт хөдөлбөргүй гэрчилнэ.

Д. Баясгалан

⁷Эртний хятадын умард хязгаарын аймаг, угсаатны товч түүх. Хөх хот. 1979, 178-р тал.